

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН УДИРДЛАГЫН НЭГДСЭН ЦАХИМ СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Газрын тухай хуулийн 24.6-д заасан газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем (цаашид “цахим систем” гэх)-ийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “аймаг, нийслэл, дүүргийн газрын алба” гэх), орон нутаг дахь хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, ерөнхий архитектор, сумын газрын даамлууд, тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

1.3.Цахим системийн үйл ажиллагааг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “хариуцагч байгууллага” гэх) улсын хэмжээнд хариуцана.

1.4.Цахим системийн үйл ажиллагаанд Газрын тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомж, журмыг дагаж мөрдөнө.

1.5.Цахим системийн өгөгдөл мэдээлэл нь Засгийн газрын баталсан солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд тулгуурласан байна.

1.6.Газрыг төлөвлөх, олгох, кадастр эрхлэх, мониторинг хийх, төлбөр татвар ногдуулах, хаяг олгох үйл ажиллагааг Засгийн газрын баталсан дараах журмын хүрээнд цахим системээр дамжуулан хэрэгжүүлнэ.Үүнд:

1.6.1.газар зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг “Газар зохион байгуулалт хийх журам”-д зааснаар;

1.6.2.газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар эзэмшүүлж, ашиглуулах үйл ажиллагааг “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-д зааснаар;

1.6.3.газар эзэмших, ашиглах эрх олгох, шилжүүлэх, барьцаалах, газрын эрхийг цуцлах, дуусгавар болгосныг бүртгэх, гэрээ байгуулж, гэрчилгээ олгох

үйл ажиллагааг “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-д зааснаар;

1.6.4.газрын төлөв байдал, мониторинг хийх үйл ажиллагааг “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”-д зааснаар;

1.6.5.нэгж талбарт хаяг олгох, бүртгэх үйл ажиллагааг “Гудамж зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-д зааснаар;

1.6.6.газрын нэгдмэл санг “Газрын нэгдмэл сангийн тайлан эрхлэх журам”-д зааснаар.

1.7.Энэ журмын 1.6-д зааснаар бусад үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд цахим системээр дамжуулан хэрэгжүүлнэ.

Хоёр.Цахим системийн системийн бүрдэл

2.1. Цахим систем нь дараах дэд системүүдээс бүрдэнэ. Үүнд:

2.1.1.газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн систем;

2.1.2.газрын кадастрын систем;

2.1.3.газрын төлбөр, татвар, үнэлгээний систем;

2.1.4.газрын мониторингийн систем;

2.1.5.хот байгуулалтын кадастрын систем;

2.1.6.газрын биржийн систем;

2.1.7.геодези, зураг зүйн систем;

2.1.8.хаягийн мэдээллийн систем;

2.1.9.газрын нэгдмэл сангийн систем.

2.2.Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн системээр газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, тэдгээрт иргэд, олон нийтийн оролцоог хангах болон хилийн цэсийн мэдээллийн санг эрхэлнэ.

2.3.Газрын кадастрын системээр газар болон бусад үл хөдлөх эд хөрөнгийн байршил, хил зааг, зураглал, талбай, эзлэхүүн, эрхийн төрөл, тэдгээрийн өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн үндсэн болон шилжилт хөдөлгөөний мэдээллийг бүртгэх, баталгаажуулах үйл ажиллагааг эрхэлнэ.

2.4.Газрын үнэлгээний системээр газрын үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлс, зах зээлийн үнийн мэдээлэл, газрын үнэлгээний тойрог, бүс, итгэлцүүр, суурь үнэлгээний мэдээллийг бүртгэх, газрын дуудлага худалдааны анхны үнийг тооцох, нэгж талбарт газрын татвар, төлбөрийг ногдуулах, нэхэмжлэх үйл ажиллагааг эрхэлнэ.

2.5.Газрын мониторингийн системээр газрын элэгдэл, эвдрэл, хөрсний бохирдол, ургамлын нөмрөгийн төрх, байдлыг тодорхойлох, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газрыг гэрээнд заасан нөхцөлөөр ашиглаж байгаа эсэх, газар ашиглалтын зөрчлийг илрүүлэх, зураглах, зөрчлийг арилгуулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх газрыг тогтоох үйл ажиллагааг эрхэлнэ.

2.6.Хот байгуулалтын кадастрын системээр инженерийн шугам сүлжээ болон барилга байгууламжийн зураг төсөл, барилгын архитектур төлөвлөлтийн

даалгавар, загвар зураг батлуулах, барилгын ажлын зөвшөөрөл, байнгын ашиглалтад хүлээн авах комиссын дүгнэлт гаргах, баталгаажуулах, тэдгээрт хяналт тавих, үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг бүртгэх, баталгаажуулах үйл ажиллагааг эрхэлнэ.

2.7.Газрын биржийн системээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулах үйл ажиллагааг эрхэлнэ.

2.8.Геодези, зураг зүйн системээр геодезийн сүлжээ, агаар, сансрын зураг, байр зүйн зураг, газар зүйн нэр, цэг тэмдэгтийн өгөгдөл, мэдээллийг цуглуулах, боловсруулах, шинэчлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, түгээх, геодези, зураг зүйн хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтыг бүртгэх үйл ажиллагааг эрхэлнэ.

2.9.Хаягийн мэдээллийн системээр нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, зам, талбай, нэгж талбар болон үл хөдлөх эд хөрөнгөд хаяг олгох, бүртгэх, хянах, тэдгээртэй холбоотой өгөгдөл, мэдээллийг цуглуулах, боловсруулах, хөгжүүлэх, түгээх үйл ажиллагааг эрхэлнэ.

2.10.Газрын нэгдмэл сангийн системээр газрын үндсэн болон дэлгэрэнгүй ангиллыг ашиглалтын зориулалт бүрээр бүртгэх, өөрчлөх, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг эрхэлнэ.

2.11.Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн систем, газрын кадастрын систем, газрын төлбөр, татвар, үнэлгээний систем, газрын мониторингийн систем, хот байгуулалтын кадастрын систем, газрын биржийн систем, геодези, зураг зүйн систем, хаягийн мэдээллийн систем, газрын нэгдмэл сангийн системүүдийн үндсэн үйл ажиллагааг зохицуулах аргачлалыг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

Гурав. Цахим системд хандах эрхийн түвшин, эрх үүргийн зохицуулалт

3.1. Цахим систем дараах эрхийн түвшинтэй байна. Үүнд:

- 3.1.1.үндсэн системийн админ;
- 3.1.2.дэд системийн админ;
- 3.1.3.хэрэглэгчийн админ;
- 3.1.4.үндсэн хэрэглэгч;
- 3.1.5.тусгай хэрэглэгч;
- 3.1.6.мэдээллийн сангийн нийлүүлэгч.

3.2.Цахим системд хандах эрхийн түвшин бүрийн удирдлага, тохиргоог хариуцагч байгууллага батална.

3.3.Үндсэн системийн админ нь хариуцагч байгууллагын мэдээлэл технологийн асуудал хариуцсан нэгжийн албан хаагч байх бөгөөд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.3.1.цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих;
- 3.3.2.дэд системийн админы эрхийн тохиргоог тухай бүр хийх;

3.3.3. өгөгдөл, мэдээллийг үр дүнтэй хадгалах, зохион байгуулах, нөөцлөх, дундын мэдээллийн санг тохируулах, мэдээллийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах;

3.3.4. программ хангамж, вэб системийн хэвийн үйл ажиллагааг хангах, хөгжүүлэх, байршуулах, засвар үйлчилгээ хийх;

3.3.5. тухайн системийн хөгжүүлэлтэд хяналт тавьж, баталгаажуулах.

3.4. Дэд системийн админ нь тухайн системийн үйл ажиллагааг хариуцсан нэгжийн албан хаагч байх бөгөөд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.4.1. улсын хэмжээнд хариуцсан дэд системийн өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, заавар зөвлөгөө өгөх;

3.4.2. үндсэн хэрэглэгч, тусгай хэрэглэгчийн эрхийн тохиргоог тухай бүр хийх;

3.4.3. дэд системийн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, баяжуулах, хадгалах, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих;

3.4.4. дэд системийн хэрэглэгч, нийлүүлэгчийг арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах;

3.4.5. мэдээлэл нийлүүлэгч байгууллагатай дундын мэдээллийн сан байгуулах, хамтран ажиллах гэрээ байгуулах;

3.4.6. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу үйлчилгээ үзүүлэх;

3.4.7. үндсэн системийн админд тухайн дэд системд нэмэлт хөгжүүлэлт хийсэн тухай бүр хүлээлгэн өгч баталгаажуулах.

3.5. Хэрэглэгчийн админ нь хариуцагч байгууллага, аймаг, нийслэлийн газрын албаны дарга байх бөгөөд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.5.1. хэрэглэгчийн админ эрхээ харьяа доод шатны албан тушаалтанд шилжүүлэх;

3.5.2. үндсэн хэрэглэгчийн тушаалыг үндэслэн бүртгэх, цуцлах тохиргоог тухай бүр хийх;

3.5.3. үндсэн хэрэглэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих.

3.6. Үндсэн хэрэглэгч нь газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн газрын албаны мэргэжилтэн, ерөнхий архитектор, сумдын газрын даамал байх бөгөөд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.6.1. энэ журмын 2.11-д заасан аргачлалын дагуу дэд системийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх;

3.6.2.өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, баяжуулах, хадгалах, ашиглах үйл ажиллагааг хариуцах;

3.6.3.цахим систем, программ хангамж, түүнтэй холбоотой нууцын зэрэглэлд хамаарагдах мэдээ, файлын бүтэц, аливаа мэдээллийг бусдад хувиран тараах, дамжуулах, санаатай болон санамсаргүй задруулахгүй байх;

3.6.4.цахим систем дэх байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээ, мэдээллийг бусдад дамжуулах, ашиглуулахгүй байх;

3.6.5.нэвтрэх нэр, нууц үгээ бусдад дамжуулахгүй байх;

3.6.6.эрх бүхий этгээдийн шийдвэргүй мэдээлэл оруулах, өөрчлөх, устгах болон алдаатай мэдээлэл оруулахгүй байх;

3.6.7.хамтран ажиллах гэрээ байгуулсан мэдээлэл нийлүүлэгчээс бусад аливаа этгээдээс мэдээлэл авах, түүнийг мэдээллийн санд оруулахгүй байх.

3.7.Тусгай хэрэглэгч нь энэ журмын 3.6-д заасан хэрэглэгчээс бусад цахим системд хандаж ажиллах төрийн болон төрийн бус байгууллагын холбогдох албан тушаалтан байх бөгөөд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.7.1.тусгай хэрэглэгч нь тухайн салбарын мэдээллийг дундын мэдээллийн системд улирал тутам оруулах, авах, тогтмол шинэчлэх, ашиглах үйл ажиллагааг эрхлэх;

3.7.2.өгөгдөл, мэдээллийн стандартад нийцсэн, үнэн зөв байдлыг хариуцах;

3.7.3.хариуцагч байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх.

3.8.Мэдээллийн сангийн нийлүүлэгч нь цахим системд шаардлагатай мэдээллээр хангах аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох албан тушаалтан байх бөгөөд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.8.1.өгөгдөл, мэдээллийг хэрэглэгчийн эрхээр нэвтэрч нийлүүлэх;

3.8.2.өгөгдөл, мэдээллийн стандартад нийцсэн, үнэн зөв байдлыг хариуцах;

3.8.3.шинээр бий болсон өгөгдөл, мэдээллийг тухай бүр нийлүүлэх;

3.8.4.хариуцагч байгууллагатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх.

Дөрөв.Дундын мэдээллийн сан

4.1.Цахим систем нь төрийн мэдээллийн бусад сан, системтэй дундын мэдээллийн сангаар холбогдон ажиллах бөгөөд мэдээллийн шинэчлэлийг тухай мэдээллийн сан хариуцсан байгууллага хариуцна.

4.2.Дундын мэдээллийн санг үүсгэж буй төрийн мэдээллийн сан, систем нь Засгийн газрын баталсан “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, ашиглах журам”-д заасныг баримтлан ажиллана. Хэрэв төрийн мэдээллийн нэгдсэн

сүлжээнд холбогдох байгууллагын жагсаалтад хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллага цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргана.

4.3.Дундын мэдээллийн сангаар мэдээлэл болон өгөгдөл солилцохдоо сервер, тоног төхөөрөмжийн сүлжээний хаягийг дундын мэдээллийн сан үүсгэж буй байгууллагууд тохируулах бөгөөд мэдээлэл солилцох асуудлыг тухайн байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.4.Дундын мэдээллийн санг үүсгэж буй төрийн мэдээллийн сан, системийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг тухайн мэдээллийн сан, систем хариуцсан байгууллага хариуцна.

4.5.Дундын мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэгч нь өгөгдөл мэдээллийг бүрдүүлэх, нийлүүлэхдээ энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомж, стандарт, заавар, арга зүйг дагаж мөрдөнө.

4.6.Дундын мэдээллийн сангаас гарч буй үйлчилгээний нэр (Service URL), төрөл (type), (Rest, JSON), төрөл HTTP (POST , GET, PUT, DELETE), оролтын утга (Input), гаралтын утга (output), параметрийн нэр (parameter name), өгөгдлийн төрөл (data type), тайлбар (description), дуудах жишээ (example) мэдээллийн дагуу гаргаж системийн админд хүлээлгэн өгнө.

Тав.Бусад байгууллагуудтай системийн интеграци хийх

5.1.Цахим системийг интеграци хийхэд дараах үйл ажиллагааг мөрдлөг болгоно. Үүнд:

5.1.1.интеграцийн шаардлагыг тодорхойлох, системийн хэрэгцээг үнэлэх, систем хооронд хуваалцах, шууд хөрвүүлэх, шаардлагатай өгөгдөл, үүргийг (function) тодорхойлох;

5.1.2.төрийн нэгдсэн сүлжээнд холбогдсон байх;

5.1.3.системийн өгөгдлийн бүтэц (format), протокол (protocol), (API)-ийн хувьд интеграци хийх боломжтой эсэхийг тодорхойлох;

5.1.4.стандарт, протоколуудыг дагаж мөрдөх;

5.1.5.өгөгдлийн зураглал, дамжуулах протоколуудыг тодорхойлох;

5.1.6.интеграцийн интерфэйсийг хөгжүүлэх;

5.1.7.систем хоорондын баталгаат найдвартай харилцааны тогтолцоог хэрэгжүүлэх;

5.1.8.туршилт, баталгаажуулалт хийх буюу систем хоорондын өгөгдлийн урсгал, харилцан хамааралтай байдал, өгөгдлийн шууд хөрвүүлэлт, бодит агшны шинэчлэлт, алдаа сэргээх зэрэг мэдээллийн үнэн зөв солилцоог хангах.

5.2.Системийг нэгтгэн оролцож буй хэрэглэгчид болон хөгжүүлэгч нь тухайн системийн оролтын утга, гаралтын утга зэрэг бусад шаардлагатай утгуудыг бүртгэж тухайн асуудлыг хариуцсан нэгжийн дэд системийн админд хүлээлгэн өгнө.

Зургаа.Цахим системийн хяналт шалгалт

6.1.Хариуцагч байгууллага нь цахим системд хяналт шалгалт хийнэ.

6.2.Цахим системийн үйл ажиллагаанд хариуцагч байгууллага хяналт шалгалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

6.3.Хариуцагч байгууллага хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг холбогдох хууль, журмын дагуу бүрэн арилгах арга хэмжээг авч ажиллана.

6.4.Цахим системийн программ хангамж, сервер, сүлжээний аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаанд хариуцагч байгууллага хяналт тавих ба хэвийн тасралтгүй үйл ажиллагааг улсын хэмжээнд бүрэн хариуцаж ажиллана.

6.5.Цахим системийн найдвартай ажиллагааг хангаж нөөц серверийг төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад байршуулна.

Долоо. Хориглох зүйл

7.1.Цахим системд хандах эрхтэй хэрэглэгч нь эрх бүхий этгээдийн зөвшөөрөл олгосон шийдвэргүйгээр мэдээлэл (алдаатай мэдээлэл) оруулах, өөрчлөх, устгахыг хориглоно.

7.2.Цахим систем, программ хангамж, түүнтэй холбоотой нууцын зэрэглэлд хамаарагдах мэдээ, файлын бүтэц, аливаа мэдээллийг бусдад хувилан тараах, дамжуулах, санаатай болон санамсаргүй задруулахыг хориглоно.

7.3. Цахим системд хандах эрх бүхий албан хаагчаас бусад этгээд уг системд хандахыг хориглоно.

7.4.Цахим системийн хэрэглэгч нь өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг бусдад дамжуулахыг хориглоно.

7.5.Энэхүү журамд заасан болон хамтран ажиллах гэрээ байгуулсан мэдээлэл нийлүүлэгчээс бусад аливаа этгээдээс мэдээлэл авах, түүнийг мэдээллийн санд оруулахыг хориглоно.

7.6.Энэ журмын 3.5.1-д заасан эрх шилжүүлж авсан албан тушаалтан бусдад эрхээ шилжүүлэхийг хориглоно.

Найм.Хүлээлгэх хариуцлага

8.1.Цахим системд хандах хэрэглэгчийн нэвтрэх нэр, нууц үг алдсан тохиолдолд нэн даруй мэдэгдээгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

8.2.Албан тушаалаас чөлөөлөгдсөн албан хаагчийн эрхийг хаалгах арга хэмжээг ажлаас чөлөөлөх тушаал гарснаас хойш 24 цагийн дотор зохион байгуулаагүй байгууллага, албан хаагчид хариуцлага хүлээлгэнэ.

8.3.Энэхүү журмын долоодугаар бүлэгт заасан хориглосон заалтыг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.